



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/240

Булган сум

**Монгол Улсын гавьяат тамирчин М.Баттүшигт
хүндэтгэл үзүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны А/377 дугаар захирамжаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгөөс тусламж, дэмжлэг олгоход баримтлах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Хутаг-Өндөр сумын уугуул, Цагдаагийн ерөнхий газрын Тусгай ажиллагааны газрын сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн хурандаа М.Баттүшиг нь Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113 жилийн ойн өдрөөр Монгол Улсын Гавьяат тамирчин цол, тэмдгээр шагнагдсан тул түүний хөдөлмөр, амжилтыг өндрөөр үнэлж, 2,000,000 (хоёр сая) төгрөгийн хүндэтгэл үзүүлсүгэй.

2.Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010315